

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
 хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг төрийн тусгай албан тушаалд хамааруулах, таван шатлал бүхий цолтой байх, гадаадын иргэний оршин суух үнэмлэх хэвлэх үйлчилгээг байгууллагын дотоод нөөц бололцоонд тулгуурлан хэвлэх зохицуулалтыг тусгах, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг тус байгууллагын дараа жилийн төсөвт тусган, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна. Түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдыг төрийн тусгай албан тушаалд хамруулах зохицуулалттай уялдуулж Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Гадаадын иргэн, харьяатын газрын орон тоо нэмэгдэхгүй бөгөөд төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн тодорхой хувийг гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт төвлөрүүлэх шаардлагатай гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайгад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүрэг бүхий Гадаадын иргэн, харьяатын газар нь үйлчилгээний байгууллага гэдгийг онцолж, тусгай чиг үүрэгтэй төрийн тусгай алба болгох шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байхад яригдсан асуудал учир хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд уг байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчийн тоо, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг 2023 оны төсвийн төсөлд тусгасан эсэх, байнга оршин суугчийн үнэмлэхийг дотоод нөөц боломжоо ашиглан хэвлэх асуудлыг хуульд тусгайлан заах шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газраас ирүүлсэн саналын

талаар, түүнчлэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой Төрийн албаны зөвлөлөөс санал авсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид тусгай чиг үүргийн хувцас форм хэрэглэх шаардлагатай эсэх, төрийн байгууллага оршин суух зөвшөөрлийг хэвлэх эрхийг авах шаардлагын талаар, түүнчлэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан тодорхой мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг тус байгууллагын дараа жилийн төсөвт тусгах асуудал нь хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлээд Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний тоо, оршин суух зөвшөөрөл олгодог нөхцөл, шаардлагын талаар болон цолны нэршлийг хэлэлцүүлгийн явцад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгааг илэрхийлээд хяналтыг сайжруулах зорилгоор харьяатын газрын эрх, үүргийг тодорхой болгож бэхжүүлэх асуудал төсөлд туссан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын хувьд Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдыг төрийн тусгай чиг үүрэгт хамааруулж, сахилга хариуцлага, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, төрийн тусгай алба нийгмийн хэв журмыг хамгаалах, үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй учраас Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан байгууллагыг төрийн тусгай алба болгосноор энэ зорилгыг хангахад ахиц гарах нөхцөлтэй байх, түүнчлэн төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баталгаагаар хангагдах ёстой учраас хэлэлцүүлгийн явцад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлаас аялал жуулчлалыг дэмжих зорилгоор хил орчмын жуулчдад өдрийн виз олгох зохицуулалтыг тусган Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангах шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн төрийн тусгай алба болсноор үүрэг гүйцэтгэхэд дөхөм болох, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой ахиц гарахыг харгалzan дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хилийн боомтод үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагуудын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг тооцож үзэхэд харьяатын газар хамгийн бага нөхцөлтэй байсан бөгөөд албан хаагчдыг төрийн тусгай чиг үүрэгт хамааруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Гадаадын иргэн, харьяатын газар нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй 11 байгууллагын нэг түүнчлэн Хилийн тухай хуульд зааснаар хилийн хяналтын байгууллагад хамаардаг тул хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж, хуулийн төслийн нэгдүгээр зүйлд заасан төсөвтэй холбоотой заалтыг хэлэлцүүлгийн явцад Төсвийн тухай хуульд нийцүүлэх талаар тус тус санал хэлсэн болно.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 84.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Л.МӨНХБААТАР